

СҮХБААТАР АЙМАГ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Тайлангийн хамрах хугацаа: 2023 он

Тайлан илгээгч: Санхүүгийн хяналт, аудитын алба

Боловсруулсан:

СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

/Т.ЦЭРЭГБАЯР /

Хүлээн авагч:

САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

/Б.ДОРЖСЭМБЭД/

2024 оны 01 дүгээр сарын 04

**СҮХБААТАР АМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН**

2024.01.03

Баруун-Урт сум.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, 69 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах, төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 2022 онд дараах 3 зорилтыг үйл ажиллагаандаа дэвшүүлэн ажиллав. Үүнд:

Зорилт 1. Төрийн байгууллагын ил тод, төрийн үйлчилгээний хүртээмжийг чанар хүртээмжийг дээшлүүлэх 1 зорилт, 7 арга хэмжээний хэрэгжилт

Зорилт . Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 1 зорилт, 8 арга хэмжээний хэрэгжилт

Зорилт . Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 1 зорилт 5 арга хэмжээ

Дээрх зорилтуудын хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэд захиргааны хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагаа буюу дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлыг үнэлж, дотоод аудитыг зохион байгуулах гэсэн үндсэн 2 чиг үүрэгтэй, Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан баталсан аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн үүргийн гүйцэтгэлийг бодитой үнэлж ажиллалаа.

Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга буюу Төсвийн Ерөнхийлөн захирагчтай “Санхүүгийн хяналт, аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г батлуулан дараах арга хэмжээнүүдийг авч ажиллан, төлөвлөгөөний биелэлт 86 хувьтай байна. 2023 онд тус алба нь 3052.8 хүн өдөр ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2798.4 хүн өдөр ажиллаж, ажлын хүн өдрийн хүчин

чадлын ашиглалт 91.6 хувьтай байна.

Нэг. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах:

Тус алба нь 2023 онд Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн ба гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр тухайн жилд аймгийн Засаг даргын болон албаны даргын баталсан удирдамжаар нийт 35 объектын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, 9 объектын үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ.

Хяналт шалгалтад төсвийн 30, орон нутгийн өмчит 4 байгууллагын үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалтыг зохион байгуулж, 33 хяналт шалгалтын танилцуулга, 2 байгууллагад дүгнэлт үйлдсэн. Тайлант онд төлөвлөгөөт хяналт шалгалт 35, төсөвт байгууллагаас 2 хүсэлт гаргасны дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт 2-г зохион байгуулан ажилласнаас нийт хяналт шалгалтын 5.7 хувийг эзэлж, хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд шалгалтаар илэрсэн нийт 1238672.8 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн 1972661 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн 20 акт тогтоож, үүнээс 96 хувь буюу 18636.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 687.0 мянган төгрөгийг тухайн байгууллагад, ажилтанд хувь буюу 402.3 мянган төгрөгийг тус тус тогтоож, одоогийн байдлаар 6384.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр барагдаж, 11695.7 мянган төгрөгийн 9 актны хугацаа болоогүй байна.

Түүнчлэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд 1217481.7 мянган төгрөгийн 36 албан шаардлага тогтоож, байгууллагад өгсөн 139134.4 мянган төгрөгийн 8 албан шаардлага хугацаа болоогүй хүлээгдэж буй гүйцэтгэлтэй, биелэлт 20 хувьтай байна.

Өмнөх 2021, 2022 онд тогтоосон буруутай шийдвэрийн улмаас төрд учруулсан хохирлыг барагдуулах 103838.2 мянган төгрөгийн биелэгдээгүй актны төлбөрийг Сүхбаатар аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн шүүхэд хандан албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт өгсөнөөр 10559.4 мянган төгрөгийн актыг баталгаажуулж, барагдсан, 93278.8 мянган төгрөгийн актыг түдгэлзүүлсэн. Мөн 1800.0 мянган төгрөгийн акт биелэгдэж орон нутгийн төсөвт төвлөрөөд байна. Түүнчлэн тус онд 2021-2022 онд хууль бус шийдвэр гаргасан нь анхан болон давж заалдах шатны шүүхээр тогтоогдож, шүүхийн шийдвэрийн дагуу 2021-2023 онуудад төсвөөс олгогдсон цалин хөлсний нөхөн төлбөрт хяналт шалгалт хийж,

шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, таслан зогсоох зорилгоор 2110632 төгрөгийн зөрчилд 1 салбар акт тогтоож шийдвэрлэлээ.

1. Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр:

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн нийт 1237207.8 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг ангилбал:

1. Үндсэн баримтгүй болон данс бүртгэлд тусгаагүй зөрчил 8.6 хувь буюу 107284.1 мянган төгрөг
2. Зориулалт бусаар зарцуулсан зөрчил 7.8 хувь буюу 95514.1 мянган төгрөг
3. Өглөг авлага үндэслэлгүй хаасан зөрчил 2.1 хувь буюу 25758.3 мянган төгрөг
4. Цалин хөлстэй холбоотой зөрчил 0.7 хувь буюу 6625.0 мянган төгрөг
5. Ашиглаж дутагдуулсан зөрчил 0.2 хувь буюу 2980.0 мянган төгрөг
6. Хандивлаж ивээн тэтгэсэн, их хэмжээгээр олгосон шагнал бэлэг дурсгал 0.2 хувь буюу 2184.9 мянган төгрөг
7. Бусдад зээлдүүлж түр ашиглуулсан 50 хувь буюу 630456.2 мянган төгрөг
8. Түрээсийн төлбөрийг дутуу ногдуулсан 0.06 хувь буюу 687.2 мянган төгрөг
9. Бусад зөрчил 31 хувь буюу 365718.2 мянган төгрөг буюу хувь тус тус эзэлж байна.

Хяналт шалгалтаар илэрч буй нийт зөрчлийн дүнд судалгаа хийхэд хамгийн их хувийг дараахь зөрчил эзэлж байна. Үүнд: 2017 онд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, дамжуулах, нутагшуулах замаар жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар экспортын болон импортыг орлох үйлдвэрлэлийг бий болгох, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор орон нутгийн сан байгуулж, нэр бүхий 10 аж ахуйн нэгжид 1 жилийн 3 хувийн хүүтэй нийт 500.3 гаруй сая төгрөгийн зээл олгосноос 2022 онд 8 аж ахуйн нэгжийн хугацаандаа төлөгдөөгүй зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл 630456.2 мянган төгрөгийн зөрчил. Дараагийн зөрчил нь сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчил шалгалтад хамрагдсан сум болгонд илэрсэн ба мөн дараагийн зөрчил нь үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, үндсэн баримтгүй зарцуулдаг зөрчил тус тус эзэлж байна.

Харин цалин хөлсийг илүү дутуу олгосон зөрчил өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Дээрх зөрчлүүдэд улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн 20 салбар акт тогтоож, зөрчлийг дор бүр нь арилгуулж, цаашид шинээр батлагдан гарч байгаа холбогдох хууль тогтоомжийг судлан, ялангуяа төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг байгууллага тус бүрээр нь гарган хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн актыг төрийн албан хаагч бүр хяналтанд авч ажиллаж байна. Үүнд: Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын сайдын тушаалыг хяналтад авч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Шалгалтаар илэрсэн зөрчигдөж буй хууль тогтоомжийн заалтуудыг дурдвал:

- 1.Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 7 дугаар зүйлийн 7.7, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, , 60 дугаар зүйл, 44 дүгээр зүйлийн 44.3, 24 дүгээр зүйлийн 24.4,
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3,
- 3.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9, 12, 13, 14, 19 дүгээр зүйл,
4. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол
5. Сангийн сайдын 61, 190, 276 дугаар тушаалууд
6. Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 01 сарын 12-ны өдрийн 05, А/12 тушаалын хавсралт “Коронавируст халдвар /Ковид19/-ыг илрүүлэх шинжилгээг хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар”

2. Дотоод аудитын чиглэлээр:

Тус алба нь 2023 онд 9 байгууллагад дотоод аудит хийхээр төлөвлөж, төлөвлөгөөний дагуу 9 байгууллагын 2021, 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна. Дотоод аудитаар илэрч буй нийтлэг зөрчлөөс дурдвал: аймгийн Музейн байгууллага нь шатахуун түгээх газартай ойр, орчны аюулгүй байдал эрсдэлтэй, байрны ашиглалтын хугацаа дууссан, стандарт шаардлагыг хангаагүй, бусад байгууллага нь дотоод аудитын нэгжийг байгуулсан боловч төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагнал байхгүй, удирдлагын зүгээс дотоод хяналтын үйл ажиллагаандаа анхаарал хандуулдаггүй, засаглах

удирдлага нь хяналт сул тавьдаг, Насан туршийн боловсролын байгууллагад хүний нөөцийн дутагдалд орсон, үр дүнгийн урамшуулал олгодоггүй зэрэг эрсдлүүд илэрсэн. Түүнчлэн 13 сумдын худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийж, аудитаар илэрсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон дагуу цахим системд байршуулдаггүй, тендерийн баримт бичгийн бүрдэл дутуу, тендерийн баримт бичигт урьдчилгаа төлбөр олгох талаар тусгаагүй байхад захиалагч гэрээнд тусгаж урьдчилгаа санхүүжилт олгосон, захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цахим системд байршуулаагүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөөгүй, гишүүд гарын үсэг зураагүй зэрэг асуудалд, мөн 13 сумын орон нутгийн хөгжлийн санд хийсэн аудитаар илэрсэн тус санд төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын гүйцэтгэл бага, иргэдээс санал аваагүй ажлуудыг төлөвлөж гүйцэтгэдэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд тавих хяналт бага, удирдлагын мэдээллийн системд оруулах мэдээллийг хангалтгүй оруулдаг, ОНХС-ийн хөрөнгөөр нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагааг санхүүжилсэн зэрэг эрсдлүүдэд нийт 45 зөвлөмж өгч ажиллалаа.

Хоёр. Албаны үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй болгох:

Сангийн Яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын цахим сайт sankhuu_audit_su@yahoo.com хаягаар ирсэн албан бичиг, санал, хүсэлтийг тухай бүр шуурхай, үнэн зөв шийдвэрлэж хариу хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргын баталсан 2023 оны 01 тоот удирдамжаар Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах орон нутгийн төсөвт байгууллага, тусгай сангууд, орон нутгийн төрийн өмчит үйлдвэрийн газрууд, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хамрагдсан байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд дотоод аудит хийж дүгнэлт өгөх, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгч ажиллав.

Гурав. Ажилтан албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх:

Тус алба нь албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдөн ажиллаж байна. Мөн албаны даргын Зөвлөлийн хурлаар улсын байцаагчид, дотоод аудитор нарын хяналт шалгалтын болон дотоод аудит хийсэн ажлын талаар тухай бүр хэлэлцэн, баримт бичгийн стандартын хэрэгжилт, хууль тогтоомжийг зөв зохистой хэрэглэж байгаа байдалд тогтмол хяналт тавьж,

хяналт шалгалт, дотоод аудитын чанар, үр дүнд анхаарал хандуулж ажиллалаа.

Дөрөв. Албаны дотоод үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт :

4.1.Тус албаны дотоод үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг зохион байгуулж, үйл ажиллагааг оновчтой болгох зорилгоор хэрэгжүүлсэн ажлын үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж, байгууллагын үйл ажиллагаанд “Ажилтан албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх” зорилт тавин төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоосон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Аймгийн Засаг даргатай 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, төр захиргааны байгууллагуудын удирдах ажилтны ээлжит шуурхай хуралдаанд оролцон, аймгийн удирдлагуудаас өгөгдсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийг тухай бүр үйл ажиллагаандаа тусган, биелэлтийг тооцон ажиллаж байна.

Хуанлийн Даваа гариг бүр “Мэдээллийн цаг” арга хэмжээг авч хэрэгжүүлж, уг ажлын хүрээнд цаг үеийн шинжтэй асуудал болон аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдааны тэмдэглэл, шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг таниулах зэргээр арга хэмжээ зохион ажиллаж хэвшсэн.

Тус байгууллагад шууд хамааралтай аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжих 3 заалтын хэрэгжилт 100%, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжих 8 заалтын хэрэгжилт 85 %-тай үүнээс санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит, үйл ажиллагааг бүх шатанд хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний 2 заалтын хэрэгжилт 100 %, аймгийн ИТХ-ын тогтоолын 3 заалтын хэрэгжилт , аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжих 26 заалтын хэрэгжилт 70 %, хууль тогтоомжийн хэрэгжих 14 заалтын хэрэгжилт 100 %-ийн гүйцэтгэлтэй, аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс тус албаны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлэлцэн 88.7 хувьтай үнэлсэн байна.

4.2. Сургалт, сурталчилгаа, арга зүйн зөвлөгөө өгч, албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:

Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, арга зүйн зөвлөгөө.

-Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, санхүүгийн сахилга батыг

дээшлүүлэх, шалгалтанд хамрагдсан байгууллагуудын шалгалтын дүн, зөрчигдсөн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам болон шалгалтаар илэрсэн зөрчлүүд, түүний шалтгаан, нөхцөл, тухайн байгууллагад ирээдүйд учирч болох эрсдэл, тэдгээрийг бууруулах чиглэлээр хяналт шалгалтад хамрагдсан 23 объектод тухай бүр уулзалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Сургалтанд сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, ажилтан, албан хаагчид болон төсөвт байгууллагуудын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнууд нийт 100 гаруй хүнийг хамруулсан байна.

Тус албаны даргын тушаалаар тус албаны ЭБАТ хариуцсан ажилтнаар санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Д.Оюунсүрэнг томилж, үүнтэй холбогдуулан ЭБАТ нь тухайн онд хийх сургалт болон ажлын төлөвлөгөөг болон байгууллагын авлига, ил тодын төлөвлөгөөг тус тус батлуулан, албан хаагчдад Авлигын эсрэг хууль болон НАНБХУСЗУСТХ-ийн талаар түүнчлэн ХАСУМ, ХОМ, хяналт шалгалт, дотоод аудит хийхээс өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ ийлэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хэрхэн ойлгомжтой, үнэн зөв мэдүүлэх талаар сургалт хийж, хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн тус албанд шинээр томилогдсон дотоод аудитор Б.Буджавт ХАСХОМ, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ хэрхэн үнэн зөв мэдүүлэх талаар зөвлөмж өгөв.

Албан хаагчдын “Сургалт хөгжил”-ийн төлөвлөгөөг албаны даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг үе шаттай сургаж байна. СШХ-ын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Д.Оюунсүрэн Сангийн Яамнаас зохион байгуулсан “Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх” сургалтад, Сангийн Яам, Дорнод Орхон аймгуудын хамтарсан “Улсын салбарын дотоод аудит” сэдэвт сургалтад албаны дарга Т.Цэрэгбаяр, ахлах дотоод аудитор Х.Хүрэлцэцэг, дотоод аудитор Б.Цэрэнпагма, Л.Цэгмэд, Б.Уянганям нар, 11 дүгээр сард Сангийн Яамнаас Улаанбаатар хотод зохион байгуулсан дотоод аудитын сургалтад 7 албан хаагч тус тус хамрагдсан.

Түүнчлэн тус алба нь 1 дүгээр сараас эхлэн Төрийн албаны Зөвлөлөөс зохион байгуулж байгаа 4.7.10 сургалтад 7 хоног бүрийн Пүрэв гараг бүр сургалтад хамрагдаж байна. 3 дугаар сард Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан Алсын хараа 20-50 хөтөлбөрийн хүрээнд онлайнаар нийт 8 албан хаагчийг хамруулж, шалгалт өгч тэнцэн бүгд сертификат авсан. 4 дүгээр сард Удирдлагын академийн ахлахын мэргэшүүлэх сургалтад албаны дарга

Т.Цэрэгбаяр аймгийн ЗДТГ-ын захиалгаар төлбөргүй суралцаж, мөн ту сургалтад ахлах дотоод аудитор Х.Хүрэлцэцэг, дотоод аудитор Л.Цэгмэд нар хувийн зардлаар суралцаж төгсөв.

4.3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Тус алба нь 2023 онд албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч-2, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 2, ахлах дотоод аудитор 1, дотоод аудитор 3, нягтлан бодлогч 1, нярав, бичиг хэргийн ажилтан-1, жолооч-1 нийт 11 орон тоотой, төсвийн хуваарийн дагуу мянган төгрөгийн санхүүжилт авч, мянган төгрөгийн зарлагатай ажилласан байна.

Байгууллагын санхүүгийн тайлан мэдээ болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.6, 6.2.1-6.2.5, 6.3.2, 6.3.3, 6.3.6, 6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.7, 6.4.9-д заасан мэдээллүүдийг Ил тод байдлын тухай, Төсвийн тухай хуулийн дагуу цахимаар болон цаасаар бүрэн мэдээлж, байршуулж тайлагнаж байна.

Сангийн Яаманд хүргүүлэх санал:

ТАЙЛАН БИЧСЭН:

АЛБАНЫ ДАРГА

Т.ЦЭРЭГБАЯР

